



# U2C HR Танилцуулга

v1 (2020.10.15)

---

[www.up2cloud.mn](http://www.up2cloud.mn)

 [service@up2cloud.mn](mailto:service@up2cloud.mn)

 99128426

 Улаанбаатар, ХУД, 3-р хороо

## U2C HR системийн тухай

UP2CLOUD компаны хүний нөөцийн удирдлагын цогц систем (HRMS) болох U2C HR - ийг танилцуулж байна.

Хүний нөөцийн удирдлагын систем нь компаны хүний нөөцийн үндсэн болон стратегийн функцүүдийг нэг цэгт төвлөрүүлсэн цогц програм хангамж юм. HRMS систем нь шинэ ажилтан сонгон шалгаруулах процес гэх мэт бичиг цаасны, цаг их зарцуулдаг, гар ажиллагаа ихтэй хүний нөөцийн үндсэн ажлуудыг хялбарчилж, ажиллах хүчийг хэмнэхээс гадна компаны удирдах үйл ажиллагааг автоматжуулж өгдөг. Мөн, HRMS нь бүх ажилтнуудад зориулсан өөртөө үйлчлэх цэс болон төвлөрсөн өгөгдлийн сантай байдаг.

UP2 HR - ийг ашиглахын давуу талууд:

- Технологийн асуудлуудаа мэргэжлийн компанид даатгана : Танай компани үнэтэй сервер худалдан авах, түүнийг аюулгүй найдвартай ажилуулах мэргэжилтэнд зарцуулах зардал, интернэт тог засвар гэх мэт урсгал зардалд гаргах мөнгийг хэмнэнэ.
- Хямд үнэ: Систем нь нээлттэй эх дээр суурилсан тул бусад ижил төрлийн системүүдтэй харьцуулбал маш хямд
- Бүрэн онлайн: Ажлаасаа, гэрээсээ, гадаадаас хаанаас ч хандаж хүссэн мэдээллээрээ хангагдах боломжтой
- Уян хатан: Өөрийн хэрэгцээнд тохируулан модулиудаас сонгох боломж
- Системийн үнэгүй сайжруулалт: Системийн өөрчлөлт сайжруулалтыг шууд авна.
- Хэлний сонголт: Англи эсвэл монгол хэлний сонголт

U2C HR систем нь хүний нөөцийн үндсэн модуль болон нэмэлт 6 модулиудаас бүрдэг.

## Үндсэн модуль

U2C HR - ийн үндсэн модульд ажилтнуудын бүрэн бүртгэл, амралт чөлөөний процес, ажлаас гарах процес, хөрөнгө хувиарлалт, зардал мөнгөний зарцуулалт, баг хамтийн ажиллагааг зохицуулалт багтана. Мөн компаны хэрэглэгчид, харилцагчдын бүртгэлийг хийх боломжтой байдаг. Үүнд, зайлшгүй шаардлагатай дараах цэснүүд орно.

## Хянах самбар (Dashboard)

Аливаа системд нэвтэрч ороход хамгийн түрүүнд харагддаг хуудсыг Хянах самбар гэж нэрлэдэг бөгөөд тухайн хэрэглэгч бүрийн онцлогт тохируулан хамгийн хэрэгтэй мэдээллүүдээр хангах зориулалттай байдаг. Манай системийн хувьд хэрэглэгч өөрийнхөө хянах самбарыг зохицуулах боломжтой буюу өөрт хамгийн чухал гэсэн цэснүүдийг сонгон байрлуулах боломжтой. Мөн ажилтнуудад зориулсан зарлал болон тухайн өдөр тохиож буй төрсөн өдрийн мэдээлэл энд харагддаг.

## Өөртөө үйлчлэх (Self Service)

Ажилтнууд систем дэх өөрийн мэдээлэлд хандаж өөрчлөлт хийх боломжтой тул тухай бүр хүний нөөцийн албанд ханддаг явдал байхгүй болно. Мөн тэдэнд чөлөө авах болон ажлаас гарах болсон тохиолдолд системээр дамжуулан процессыг эхлүүлэх, хянах боломж олгодог. Удирлагуудын хувьд энэ хэсэгт өөрийн мэдээллээс гадна өөрийн удирдлаганд ажиллаж буй ажилтнуудын мэдээллийг хянах, чөлөөний болон ажлаас гарах өргөдлүүдэд зөвшөөрөл өгөх боломжтой. Байгууллагын албан ёсны амралтын өдрүүдийн мэдээллийг мөн авна.

## Хүний нөөц (HR)

Хүний нөөцийн ажилтнууд болон байгууллагуудын удирдлагууд (Management role)-д энэ меню харагдах бөгөөд хүний нөөцийн бүртгэл, бүрдүүлэлт энд байна. Мөн бүртгэл болон хүний нөөцийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай суурь мэдээллүүдийг энд оруулж өгдөг.

## Байгууллага (Organization)

Байгууллагын үндсэн мэдээллүүд (нэр, хаяг, цахим шуудан, утас, лого гэх мэт) болон салбар нэгжүүдийн мэдээллийг энд оруулдаг. Энд мөн дотоод мэдээ мэдээлийг (announcement) оруулах, байгууллагын дотор ашиглагддаг бүх бичиг баримтын санг үүсгэх цэснүүд байрладаг. Бичиг баримтын санг бүлэглэн маш цэгцтэй харуулдаг тул ажилтнуудын хувьд өөрт хэрэгтэй файлаа нэг газраас маш хурдан олж авах боломжийг олгодог. Байгууллагын бүтэц болон ажилтнуудын шууд удирдлагыг график байдлаар харах бас боломжтой. Мөн харилцагчид болон хэрэглэгчдийн бүртгэл, байгууллагад хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлсэн төслүүдийн мэдээлийн санг энд бүрдүүлнэ.

## Зардал (Expenses)

Ажилтнуудын ажил хийх явцад гарсан төлбөр тооцооны мэдээллийн санг энд үүсгэнэ. Ажилтан бүр тухайн өдөр хийсэн төлбөр тооцоогоо дэлгэрэнгүй оруулах боломжтой

бөгөөд түүнийг шууд удирдлага нь болон компаны удирдлага, мөн эрх бүхий бусад ажилтнууд хянах боломжтой болно. Мөн ажилтнуудын бизнес аялалд зарцуулсан зардлын бүртгэл, ажилтанд олгосон уридчилгаа мөнгөний бүртгэл болон түүний зарцуулалтыг хянах боломжтой болно.

## Хөрөнгө (Assets)

Компаны худалдаж авсан бүх хөрөнгийн бүртгэлийн санг энд хийх боломжтой. Бүх хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг эрх бүхий ажилтнууд хянах боломжтой бөгөөд бусад ажилтнуудын хувьд зөвхөн өөрт харъяалагдах хөрөнгүүдийг Self Service доторхи өөрийн мэдээллийн хэсгээс харж болно.

## Нэмэлт модулиуд

Та үндсэн модуль дээр нэмээд дараах нэмэлт модулиудаас өөрийн хэрэгцээнд зориулан сонгон авах боломжтой.

## Сонгон шалгаруулалт (Recruitments)

Шинээр ажилтан сонгон авах нарийн төвөгтэй процессыг автомажуулна. Үүнд, компаны хаа нэгтэй шинэ ажилтан шаардлагатай гэсэн хүсэлтээс эхлээд, уг хүсэлтийг баталгаажуулах, түүн дээр ажил горилогчдыг бүртгэх, ажил горилогч нартай хийх ярилцлагуудыг (нэгээс олон байж болно) төлөвлөж явуулах, шаардлага хангасан ажилтны сонгон авах гэм мэт бүх үйл ажиллагааг уг модулийн тусламжтай хялбараар явуулах боломжтой. Мөн давхар танай компаныг сонирхож буй ажил горилогчдын мэдээллийн сан үүсэх ач холбогдолтой.

## Ажилтны үнэлгээ (Appraisals)

Байгууллага нь ажилтнуудынхаа гүйцэтгэлийн үнэлгээг сайн явуулж чадах юм бол шагнал урамшуулал бодох, цалингийн хэмжээг тогтоох, ажлын гэрээн дээр өөрчлөлт оруулах, хичээл сургалтанд хамруулах гээд хүний нөөцтэй хамааралтай олон чухал шийдвэрийг оновчтой хийх боломж байдаг. Энэ модуль нь ажилтнуудаа үнэлэх нарийн төвөгтэй процесийг автоматжуулж өгнө. Мөн ажилтнууд нь өөрийн шууд удирдлагаа дүгнэж дээд удирдлагын түвшинд (management) санаа бодлоо хүргэх боломжоор хангагдсан.

## Цагийн тооцоо (Time)

Цаг бүртгэлийн үйл ажиллагааг ажилтан төвтэйгээр явуулах боломжтой. Ажилтан бүр ямар ажлуудыг хэдэн цаг хийснээ өрөр бүрээр 7 хоногийн давтамжтай системд оруулдаг. Энэ процес нь компаны ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг маш тодорхой болгодог ач холбогдолтой юм. Ажилтны оруулсан цагийн тооцоог шууд удирдлага нь баталгаажуулснаар тухайн ажилтны нийт ажилласан цаг бүрэлдэхээс гадна тухайн төслийн болон компаны нийт хийгдэх ёстой ажлуудын гүйцэтгэлийн хувийг илүү тодорхой болгоход тусалдаг.

## Дотоод үйлчилгээ хүсэлт (Service Request)

Компаны дотор аливаа процес үйлчилгээ ихэвчлэн амаар эсвэл имайлээр хүсэлт явуулах замаар явагддаг. Ариа боловсронгуй хувилбар нь хэвлэмэл загвар ашигладаг боловч эдгээр нь бүгд цаг их үрсэн, эцсийн үр дүн нь юу болсон нь тодорхойгүй, шууд удирдлагад мэдээлэл очдоггүй гэх мэт сул талуудтай байдаг. Манай HRMS системийн дотоод процес үйлчилгээний модулийг ашигласнаас энэ бүх асуудлууд шийдэгдэнэ. Мөн ажилтнуудын хэзээ хэн юу хийснийг тодорхой харах боломжтой болдог.

## Үзлэг шалгалт (Background check)

Энэ модуль нь ажилтнуудын болон ажилд орохоор бүртгүүлэгчдийн мэдээллийг гадны мэргэжлийн байгууллагуудаар үзүүлж хянуулах зорилготой. Манай ихэнх компаниудын хувьд хийгддэг ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийг энэ модулиар гүйцэтгэх боломжтой.

## Шинжилгээ, тайлан (Analytics)

Хүний нөөцийн системд байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанаас гадна олон төрлийн мэдээллийн сан үүсэж байгаа. Тэдгээр сангаас хүссэн мэдээллээ тодорхой нөхцлийн дагуу хайж олох боломжийг олгоно. Мөн хайсан мэдээллээ pdf эсвэл excel форматаар татаж авах боломжтой.

## Суурилуулалтын бусад боломж

Хэрэв та манай серверийг (cloud) ашиглах сонирхолгүй байвал өөрийн компани дээр (on-premises) суурилуулан ашиглах боломжтой. Та өөрийн компанид системийг 2 янзаар суурилуулж ашиглаж болно.

Сервер дээр суурилуулах

Хэрвээ танай компани мэдээлэл технологийн албатай бөгөөд өөрийн сервертэй эсвэл сервер ажиллуулах санхүүгийн болоод мэргэжлийн боломж бололцоо байгаа тохиолдолд бид танай сервер дээр програмыг суурилуулж өгнө.

### Компьютер дээр суурилуулах

Аль нэг хүний нөөцийн ажилтны компьютер дээр системийг суулгаж болно. Компаны бусад ажилтнууд ашиглахын тулд дотоод сүлжээтэй байх ёстой. Сул тал гэвэл тухайн ажилтны компьютер байнгийн асаалттай байх хэрэгтэй болох бөгөөд уг компьютерт асуудал гарсан үед програмыг ашиглах боломгүй болно. Бүр цаашлаад бүх өгөгдлөө алдаж болзошгүй. Мөн онлайн биш учраас компани дотроо байгаа үед л ашиглах боломжтой.